



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/597

Булган сум

Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх,
хамгаалах, тэмцэх зорилгоор сургалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сум, сум дундын ойн анги, сумдын байгаль хамгаалагч, ойн мэргэжлийн байгууллагын төлөөлөлд “Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх”, “Ойн цэвэрлэгээний экологи-эдийн засгийн ач холбогдол”-ын сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 09 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх”, “Ойн цэвэрлэгээний экологи-эдийн засгийн ач холбогдол”-ын сургалтын удирдамжийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зохион байгуулах сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардлагатай 25 353 000 (хорин таван сая гурван зуун тавин гурван мянга) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний “Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх зорилгоор төвийн бүсийн сургалт зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



0321019810

Аймгийн Засаг даргын 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 157 дүгээр дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх, зорилгоор ойн хортонд нэрвэгдсэн талбайд ойн цэвэрлэгээг хийж эдийн засгийн эргэлтэд оруулах талаар үзүүлэх сургалт зохион байгуулах ажлын удирдамж

Нэг.Зорилго

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд ойн мэргэжлийн байгууллага, байгаль хамгаалагч, ойн ангийн мэргэжилтнүүдэд ойн цэвэрлэгээний арга хэмжээний зорилго, ач холбогдол, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх технологи үйл ажиллагаа, ойн нөөцийг ашиглахад ойн экосистемд халгүй арга, технологи хэрэглэх, ойн хөнөөлт, шавжаас урьдчилан сэргийлэх байгальд ээлтэй технологийг ашиглах тэмцэх зэрэг арга хэмжээг олон нийтэд тодорхой мэдээлж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Хоёр.Сургалтын арга

Ойн санг хамгаалах, “Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх”, “Ойн цэвэрлэгээний экологи-эдийн засгийн ач холбогдол”-ын талаарх үзүүлэх сургалтыг онолын болон практикт үндэслэн ойн нөөцийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр зохион байгуулна.

Гурав.Хамрах хүрээ

Сум, сум дундын ойн ангиуд, сумдын байгаль хамгаалагч нар ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл оролцоно.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа

Булган сум, Орхон сум, Бугат суманд 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 09 дүгээр сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулна.

Тав.Үр дүн

- Ойн тухай хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж буй ойн аж ахуй арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилт сайжирна.
- Ойн санг хамгаалах, ойн хөнөөлт шавжийг танин мэдэх, ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх, байгаль орчноо хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ.
- Ойн цэвэрлэгээний арга хэмжээ явуулах ойн санг тусгаарлах, зөв зохистой ашиглалтыг явуулах арга барилгыг эзэмшинэ.
- Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх технологийн карт боловсруулах арга зүй эзэмшинэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 1597 дүгээр/дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх зорилгоор ойн хортонд нэрвэгдсэн талбайд ойн цэвэрлэгээг хийж эдийн засгийн эргэлтэд оруулах талаар үзүүлэх сургалт”-ын хөтөлбөр

Сэдэв: “Ойн доройтол, хомсдолоос урьдчилан сэргийлж, ойн цэвэрлэгээний экологи-эдийн засгийн ач холбогдлын талаар үзүүлэх болон туршилтын сургалт”

Хугацаа: 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 09 дүгээр сарын 06-ны дуустал

Зохион байгуулагч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, ШУТИС-ийн харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн, Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум дундын ойн анги оролцоно.

Хугацаа	Сэдэв, чиглэл	Илтгэгч /хариуцагч
2024 оны 09 дүгээр сарын 05		
8:30-09:00	Сургалтад оролцогчдыг бүртгэх	БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Цасанчимэг
9:00-9:10	Сургалтын нээлт	ЗГХА, Ойн газрын ойн ашиглалтын хэлтсийн дарга Г.Бат БОАЖГ-ын дарга А.Гантөмөр
9:10-9:40	Монгол орны хэмжээнд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулж буй арга хэлбэр	ЗГХА, Ойн газрын ойн нөөцийн ашиглалтын хэлтсийн дарга Г.Бат
9:40-10:00	Булган аймгийн ойн хортны тархалтын талаар	“Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-ын тэргүүн докторант И.Дорж
10:00-10:50	Ойн хортон шавжид нэрвэгдсэн талбайд ойн цэвэрлэгээний арга хэмжээ явуулах зорилго, ач холбогдол, тус арга хэмжээг төлөвлөх арга зүй	ОМССХ, ЭША доктор Ph.D Ч.Ганбаатар
10:50-11:10	Цайны завсарлага	БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Цасанчимэг
11:10-12:00	Ойн нөөц ашиглалтын өнөөгийн байдал, хууль бус ашиглалтын талаар баримталж буй бодлого, арга хэмжээ	ЗГХА, Ойн газрын ахлах мэргэжилтэн Р.Ганбат
12:00-12:50	Ойн цэвэрлэгээний арга хэмжээ явуулах талбайг тусгаарлах, технологийн карт боловсруулах аргачлал	ОМССХ, ЭША Б.Баярсайхан
12:50-14:00	Үдийн завсарлага	БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Цасанчимэг, Э.Очирбат
14:00-14:30	Ойн хөнөөлт шавжийг танин мэдэх, хөнөөл учруулах үе шат	ШУА-ын Биологийн хүрээлэнгийн шавж судлаач доктор Ph.D Д.Алтанчимэг
14:30-14:50	Ойн цэвэрлэгээгээр гарсан модон материалын хэмжээг тооцох арга зүй	ОМССХ, ЭША Ч.Ганбаатар
14:50-15:40	Ойн цэвэрлэгээний арга хэмжээг тооцох арга зүй	ОМССХ, ЭНБ Дарга С.Мурзабек
15:40-16:00	Цайны завсарлага	БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Цасанчимэг

16:00-16:50	Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх арга	“Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-ын тэргүүн докторант И.Дорж
16:50-17:40	Цэвэрлэгээний арга хэмжээ явагдсан ойн талбайг нөхөн сэргээж төлөвлөлт	ОМССХ, ЭША Б.Баярсайхан
17:40-18:00	Хичээлийн хэлэлцүүлэг	Сургагч багш нар
18:00-19:00	Оройн хоол	
2024 оны 09 дүгээр сарын 06		
09:00-10:00	Сургалтын ойн талбай руу хөдлөх	
10:00-11:30	Ойн хөнөөлт, шавжтай тэмцэх зайлшгүй талбайг сонгох арга	“Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-ын тэргүүн докторант И.Дорж
11:30-13:00	Ойн цэвэрлэгээ хийх талбайн тусгаарлалтын үзүүлэх сургалт	ОМССХ, ЭША Б.Баярсайхан, багш нар
13:00-14:00	Үдийн завсарлага	БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Цасанчимэг
14:00-14:30	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх арга	“Гранд форест” ХХК-ний захирал Б.Жавхлантөгс
14:30-16:30	Дроноор тэмцлийн ажил явуулах үзүүлэх сургалт	“Гранд форест” ХХК-ний захирал Б.Жавхлантөгс Инженер техникийн ажилчид
16:30-17:30	Цэвэрлэгээгээр гарсан модон материалын хэмжээг тооцох сургалт	ОМССХ, ЭНБ Дарга С.Мурзабек, багш нар
17:30-18:00	Хичээлийн хэлэлцүүлэг	Сургагч багш нар
18:00-18:30	Оройн хоол	

Аймгийн Засаг даргын 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 1597 дүгээр дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

“Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх, ойн хортонд нэрвэгдсэн талбайд ойн цэвэрлэгээг хийж эдийн засгийн эргэлтэд оруулах талаар үзүүлэх сургалт”-ын зардал

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
Хоол, байрны зардал					
1	Байр	хоног	90/2	65 000	11 700 000
2	Өглөө, өдөр хоол	хоног	90/2	35 000	6 300 000
3	Оройн хоол	хоног	90/2	20 000	2 700 000
4	Цай (өглөө, их үд)	хоног	90/4	1 250	450 000
Дүн				125 000	21 150 000
Түрээс, хэвлэлийн зардал					
1	Сургалтын багш	хүн/өдөр	2/2	400 000	1 600 000
2	Хэвлэл 4х6 хулдаас	м2	1	307 000	307 000
3	Үзүүлэх сургалтын дрон тээвэр (Улаанбаатар хот)	Литр	126	3580	451 080
4	Дрон ажиллуулах ажилчдын хөлс	Хүн	3*2	170 000	1 020 000
5	Карате бодис	литр	10	80 000	800 000
6	Дронд ашиглах шатахуун	литр	10	2520	25 200
Дүн					4 203 000
Нийт дүн					25 353 000